Хүүхэд сэгсрэх хамшинжийн талаарх ээжүүдийн мэдлэг, дадлыг үнэлэх

Ж.Батзул[1], Ц.Уртнасан[1], Г.Түмэндэлгэр[1]
Э.Наранцэцэг[2]

[1]АШУҮИС-ийн Сувилахуйн сургууль
[2]АШУҮИС-ийн Сувилахуйн сургууль, ЭБЭХСТ
Цахим шуудан: bn19d054@st.mnums.edu.mn, Утас: 95373115

Түлхүүр үг:
Хүүхэд сэгсрэх хамшинж ээжүүд мэдлэг, дадал

Товч утга
Үндэслэл: Хүүхдийг сэгсэрснээс үүдэлтэй тархины гэмтэл үүсэхийг хүүхэд сэгсрэх хамшинж (ХСХШ) гэнэ. Нярай, бага насны хүүхдийн тархи жижиг, зөөлөн байдгаас гавлын ясыг бүрэн дүүргэдэггүй тул сэгсрэх үед тархи гавлын ясыг мөргөж цохидог. Мөн тархины мэдрэлийн эсийн миелин бүрхүүл бүрэн гүйцэт хөгжөөгүй, нярайн толгой их биенээсээ хүнд, хүзүүний булчин сул хөгжсөн зэрэг онцлогоос хамааран сэгсрэх хамшинж тохиолддог. Сэгсэрснээс үүдэлтэй толгойн гэмтэл нь тархины цус харвалт, нүдний торлог бүрхэвчинд цус харвах, нуруу нугасны гэмтэл, саажилт, таталт, хэл яриа анхаарал төвлөрөлт муудах зэрэг хүндрэлийг үүсгэдэг учраас хүүхэд сэгсрэх хамшинжийн талаар ээжүүдийн мэдлэг, дадлыг үнэлсэн судалгаа байхгүй учраас цаашид эрсдэлээс сэргийлэх ажлыг зохион байгуулахад үндэслэл нотолгоо болох тул энэхүү судалгааны ажлыг хийх болсон. **Зорилго:** Хүүхэд сэгсрэх хамшинжийн талаарх ээжийн мэдлэг, дадал, нөлөөлөх зарим хүчин зүйлийг үнэлэх. **Арга, аргачлал**: ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй 0-12 сартай 240 хүүхдийн ээжүүдийг хамруулан 3 бүлэг 39 асуумжийг авсан. Хүүхдийн сэгсрэх хамшинжийн талаарх ээжийн мэдлэгийг үнэлэхдээ 100%-иас тооцож 0-59% мэдлэггүй, 60-100% мэдлэгтэй гэж үзсэн. **Үр дүн:** Хүүхэд сэгсрэх хамшинжийн талаарх ээжүүдийн мэдлэгийг үнэлэх судалгаанд 240 (дундаж нас 30.58±6.601) оролцогч хамрагдсан. Хүүхэд сэгсрэх хамшинжийн талаар ээжүүдийн мэдлэгийг үнэлэхэд 67.5% мэдлэг муу, 17.1% нь мэдлэг дунд, 15.4% нь мэдлэг сайн байв. Судалгаанд оролцогчдын 70% нь давтан төрөгч, 30% анхан төрөгч ээжүүд байсан. **Дүгнэлт:** Хүүхэд сэгсрэх хамшинжийн талаарх ээжүүдийн мэдлэг муу байна. Хүүхэд сэгсрэх хамшинжийн талаарх ээжүүдийн мэдлэг боловсролын түвшингээс хамаарч ялгаатай байна. Мөн давтан төрөгч ээжүүд, анхан төрөгч ээжүүдээс мэдлэгийн хувьд илүү байна. Ээжүүдийн дунд хүүхдээ сэгсрэх дадал их байна. Хүүхдээ сэгсрэх дадал нь тухайн ээжийн ХСХШ-ийн талаарх мэдлэгтэй шууд хамааралтай байна. Сэтгэлзүйн асуудалтай, сүүлийн [1] сарын хугацаанд стресст өртсөн ээжүүд хүүхдээ сэгсрэх дадал давамгайлж байна. Цаашид ээжүүдэд ХСХШ-ийн талаар, хэрхэн урьдчилсан сэргийлэх талаар эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг нэмэгдүүлж хүүхдийн тархины гэмтэлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай байна.

Үндэслэл: Анагаахын шинжлэх ухаанд сүүлийн жилүүдэд хүүхдэд тохиолддог шинэ гэмтлийг олж нээгээд байна. Хүүхдийг сэгсэрснээс үүдэлтэй тархины гэмтэл үүсэхийг хүүхэд сэгсрэх хамшинж гэнэ. Нярай, бага насны хүүхдийн тархи жижиг, зөөлөн байдгаас гавлын ясыг бүрэн дүүргэдэггүй тул сэгсрэх үед тархи гавлын ясыг мөргөж цохидог. Мөн тархины мэдрэлийн эсийн миелин бүрхүүл бүрэн гүйцэт хөгжөөгүй, нярайн толгой их биенээсээ хүнд, хүзүүний булчин сул хөгжсөн зэрэг онцлогоос хамааран сэгсрэх хамшинж тохиолддог.[1] Сэгсэрснээс үүдэлтэй толгойн гэмтэл нь тархины цус харвалт, нүдний торлог бүрхэвчинд цус харвах, нуруу нугасны гэмтэл, саажилт, таталт, хэл яриа, анхаарал төвлөрөлт муудах зэрэг хүндрэлийг үүсгэдэг.[2] Сэгсэрснээс үүдэлтэй тархины гэмтэл авсан хүүхдүүдийн 40-50% нь насан туршдаа хөгжлийн бэрхшээлтэй, 25-30% нь нас барж, харин үлдсэн хэсэг нь хэл яриа, анхаарал төвлөрөлт мууддаг. Хүүхэд сэгсрэх хамшинж нь тархины гэмтэлийн улмаас нас барах гол шалтгаан болдог.[3] Marcinkowska U нарын 2018 онд хийсэн судалгаанд эцэг эхчүүдийн хүүхэд сэгсрэх хамшинжийн талаарх мэдлэгийг шалгасан бөгөөд 50.3% нь шинээр төрсөн хүүхдийг сэгсрэх

нь эрсдэлтэй гэдгийг мэддэггүй байсан бол 24% нь сэгсрэх нь эрсдэлтэй гэж үзсэн байна.[4] Aiomran HI нарын 2022 онд хийсэн судалгаанд хүүхдийн сэгсрэх хамшинжийн талаарх ээжүүдийн мэдлэг, хандлагыг үнэлэхэд 57.6% бага насны хүүхдээ сэгсэрдэг. Судалгаанд оролцогчдын 67.3% нь хүүхдийг сэгсрэх нь эрсдэлтэй талаар мэдлэггүй байна.[5] Дээрх судалгаанаас үзэхэд дэлхийн олон оронд хүүхэд сэгсрэх хамшинжийн талаарх ээжүүдийн мэдлэг, дадал дутмаг байна. Манай оронд хүүхдийг сэгсэрснээс үүдэлтэй хүүхдийн тархины гэмтэл их тохиолдож байгаа бөгөөд ээжүүдийн мэдлэг, дадлыг үнэлсэн судалгаа байхгүй учраас цаашид эрсдэлээс сэргийлэх ажлыг зохион байгуулахад үндэслэл нотолгоо болох тул энэхүү судалгааны ажлыг хийх болсон.

Зорилго: Хүүхэд сэгсрэх хамшинжийн талаарх ээжийн мэдлэг, дадал, нөлөөлөх зарим хүчин зүйлийг үнэлэх.

Арга, аргачлал: Хүүхэд сэгсрэх хамшинжийн талаарх ээжүүдийн мэдлэг, дадлыг үнэлэх судалгааг нэг агшингийн загвараар, тоон судалгааны аргаар хийсэн. Судалгаанд ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлэгт хэвтэн хэвтэн эмчлүүлсэн 0-12 сартай хүүхдийн 240 ээжийг хамруулж мэдлэг, дадлыг үнэлэх зорилгоор 3 бүлэг 39 асуумж авч мэдлэгийг үнэлэхдээ 100%-иар тооцон 0-59% бол муу мэдлэгтэй, 60-79% дунд мэдлэгтэй, 80-100% бол сайн мэдлэгтэй (0-59% мэдлэггүй, 60-100% мэдлэгтэй) гэж үнэлсэн. Судалгааны мэдээллийг SPSS25 программд оруулж бодолтыг хийсэн. АШУҮИС-ийн Судалгааны Ёс Зүйн Хяналтын хорооны 2023 оны 12 дүгээр сарын 20-ны өдрийн хурлаар (№2023/3-01) хэлэлцүүлэн судалгааны ажлыг хийх ёс зүйн зөвшөөрөл авч судалгааг хийсэн.

Үр дүн: Энэхүү судалгаанд ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 0-12 сартай хүүхдтэй 240 ээжийг (дундаж нас 30.58±6.60) хамруулан хүүхэд сэгсрэх хамшинжийн талаарх мэдлэг, дадлыг үнэлэв. Боловсролын зэргээр нь авч үзэхэд бага-дунд боловсролтой 1.9%, бүрэн дунд болвсролтой 34.6%, дээд боловсролтой 50.4%, магистрын зэрэгтэй 13.3%-ийг тус тус эзэлж байв. Гэрлэлтийн байдлаар нь авч үзэхэд гэрлэсэн 78.8%, ганц бие 3.8%, хамтран амьдрагч 17.5%-ийг эзэлж байв. Үндсэн харъяалалаар нь авч үзэхэд Улаанбаатар хотынх 53.3%, хөдөө орон нутгийнх 46.7%-ийг эзэлж байв. Ажил эрхлэлтийн байдлаар нь авч үзэхэд ажил эрхэлдэг 42.1%, ажил эрхэлдэггүй 57.9%-ийг эзэлж байв.

Хүүхэд сэгсрэх хам шинжийн талаарх ээжүүдийн мэдлэгийг үнэлэхэд 67.5% мэдлэг муу, 17.1% нь мэдлэг дунд, 15.4% нь мэдлэг сайн байв. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын хүүхэд сэгсрэх хамшинжийн талаарх мэдлэгийг үнэлсэн байдал

Үзүүлэлт	Нийт	
	Тоо	Хувь
Хүүхэд сэгсрэх хамшинжийн талаарх ерөнхий мэдлэгийн түвшин		
Муу мэдлэгтэй(0-59)	162	67.5
Дунд мэдлэгтэй(60-79)	41	17.1
Сайн мэдлэгтэй (80-100)	37	15.4
Нийт	240	100

Судалгаанд ороцогчдын 70% нь давтан төрөгч, 30% анхан төрөгч ээжүүд байсан. Анхан төрөгч ээжүүдийн 73.6% нь хүүхэд сэгсрэх хам шинжийн талаарх мэдлэг муу байсан. Анхан төрөгч, давтан төрөгч ээжүүд хүүхэд сэгсрэх хам шинжийн талаар мэдлэгийн түвшин статистик ач холбогдол бүхий ($p<0.018$) ялгаатай байна. Боловсролын түвшинг хүүхэд сэгсрэх хам шинжийн талаарх ээжүүдийн мэдлэгтэй хамааруулахад статистик ач холбогдол бүхий ($p<0.023$) ялгаатай байсан. Эдгээр үр дүнгээс харахад хүүхэд сэгсрэх хам шинжийн талаарх мэдлэгэд тухайн ээжийн боловсролын түвшин болон төрөлтийн давтамж нөлөөлж байна. Харин Нас болон харъяалалыг мэдлэгтэй хамааруулж үзэхэд статистик ач холбогдол бүхий ялгаа гарсангүй. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын хүүхэд сэгсрэх хамшинжийн талаарх мэдлэгийг ерөнхий мэдээлэлтэй харьцуулсан дүн

Үзүүүлэлт		Мэдлэггүй		Мэдлэгтэй		Нийт		p утга
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	
Нас								
	25-аас доош	41	25.3	18	23.1	59	24.6	0.707
	25-аас дээш	121	74.7	60	76.9	181	75.4	
Боловсролын түвшин								
	Бага дунд	3	1.9	1	1.3	4	1.7	0.023*

Судалгаанд оролцогчдын дадлыг үнэлэхэд ээжүүд хүүхдээ уйлаад тайвшрахгүй үед, өөрөө стресстэй байх үед, хүүхдээ өхөөрдөх үедээ 82.5% нь хүүхдээ сэгсэрч байжээ. Хүүхдээ сэгсрэх дадлыг сэтгэл зүйн асуудал ($p<0.040$), сүүлийн 1 сард стрессдсэн ($p<0.000$) байдалтай хамааруулахад статистик ач холбогдол бүхий ялгаатай байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын хүүхэд сэгсрэх дадлыг сэтгэл зүйн байдалтай харьцуулсан дүн

Үзүүүлэлт		Сэгсэрдэг		Сэгсэрдэггүй		Нийт		p утга
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	
Таньд сэтгэл зүйн ямар нэг асуудал байна уу?								
	Тийм	48	23.9	4	9.5	51	21.3	0.040*
	Үгүй	150	76.1	38	90.5	188	78.7	
Та сүүлийн нэг сарын хугацаанд стрессдсэн үү?								
	Тийм	122	61.6	13	31.0	135	56.3	0.000***
	Үгүй	76	38.4	29	69.0	105	43.8	
Нийт		198	82.5	42	17.5	240	100.0	

Хэлцэмж: Энэхүү судалгаагаар ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлэгт хүүхэд нь хэвтэн эмчлүүлсэн 0-1 насны хүүхэдтэй 240 ээжийг судалгаанд хамруулж хүүхэд сэгсрэх хамшинжийн талаарх мэдлэг, дадлыг үнэлэв. Судалгаанд хамрагдсан эжжүүдээс ерөнхий мэдээллийн 16 асуумж, ХСХШ-ийн талаар мэдлэгийг үнэлэх 10 асуумж, ХСХШ-ийн талаарх дадлыг үнэлэх 13 асуумж нийт 39 асуумжаар үнэлсэн.

Дэлхийн олон орны судлаачид ХСХШ-ийн талаарх ээжүүдийн мэдлэг, хандлагыг тодорхойлох судалгааг хийсэн байна. Adham SA нар 2019 онд ХСХШ-ийн мэдлэг, хандлагын талаар хийсэн судалгаагаар эхчүүдийн 40.1% мэдлэггүй болох нь тогтоогдсон.[5] Бидний судалгаанд хамрагдсан оролцогчдын ХСХШ-ийн талаарх мэдлэгийг үнэлэхэд 67.5% нь мэдлэггүй байсан. Судлаач Сахар Ашоур Адам (Sahar Ashour Adham) нарын судалгааны үр дүнтэй харьцуулахад бидний судалгааны мэдлэгийн түвшин бага байна.

Alzahrani F нарын 2023 онд Саудын Арабын Жедда хотын эцэг эхчүүдийн дунд хүүхэд сэгсрэх хамшинжийн талаарх мэдлэг, дадлыг үнэлэх судалгаа хийжээ. Судалгаанд оролцогчдын 30.7% нь хүүхэд сэгсрэх хамшинжийн талаар мэдлэгтэй гэж үнэлэгдсэн, 23.9% хүүхдээ тэвэрч байхдаа сэгсэрдэг, 41.4% нь хүүхдээ өхөөрдөж дээш доош агаарт өргөдөг гэж үнэлэгдсэн, мэдлэгийн түвшинг хүн ам зүйн мэдээлэлтэй хамааруулахад статистик ач холбогдол бүхий ялгаа гараагүй байна. Судалгаанд оролцогчдийн 84.0% нь цаашид хүүхэд сэгсрэх хамшинжийн талаарх мэдлэгийг авах хүсэлтэй байна.[4] Бидний судалгаанд хамрагдсан оролцогчдын 32.5% нь хүүхэд сэгсрэх хамшинжийн талаар мэдлэгтэй гэж үнэлэгдсэн, 35.0% нь хүүхдээ тэвэрч бүүвэйлэхдээ сэгсэрдэг, 43.8 % хүүхдээ өхөөрдсөн үедээ дээш доош өргөж сэгсэрдэг, 28.7% нь хүүхдээ уйлаад тайвшрахгүй үед нь сэгсэрдэг гэсэн үр дүн гарсан нь Судлаач Fatma Alzahrani нарын үр дүнтэй дүйж байна. El Sayed A нарын 2020 онд хийсэн Хүүхэд сэгсрэх хамшинжийн аюулын талаар эцэг эхчүүдийн мэдлэгийг үнэлсэн судалгаанд эмэгтэйчүүдийн хүүхэд сэгрэх хамшинжийн талаарх мэдлэг эрэгтэйчүүдээс хамаагүй өндөр байв. Энэхүү судалгаанд мэдлэгтэй оролцогчдын дунд интернетээс мэдээлэл авдаг нь тогтоогдсон хамгийн түгээмэл мэдээллийн эх сурвалж (46.1%), нийгмийн сүлжээ, гэр бүл, хөршүүд 32.3% нь эх үүсвэрийн дийлэнх хувийг эзэлж байна.[5] Бидний судалгаанд эрэгтэй хүмүүс хамрагдаагүй судалгаанд оролцогч ээжүүдийн 35.0% нь өмнө хүүхэд сэгсрэх хамшинжийн талаар мэдээлэл авч байсан. Судалгаанд оролцогчдын мэдээлэл авсан эх үүсвэрийг судлахахд цахим орчноос 19.2% нь 15.4% нь эрүүл мэндийн байгууллагын ажилтанаас, 5.4% нь гэр бүлийн гишүүдээс, 5.0 % нь гэр телевизээс, 2.9% найз нөхдөөсөө ХСХШ-ийн талаар мэдээлэл авсан байна. Цаашид ХСХШ-ийн талаарх мэдээллийг хаанаас авах хүсэлтэй байгааг судлахад 77.5 % нь эрүүл мэндийн байгууллагын ажилтанаас мэдээлэл авах хүсэлтэй байв.[1] Судлаач Azza Ismail Ismail El Sayed нарын үр дүнгээс ялгаатай байгаа нь судалгааны түүвэр, тухайн улс орны нийгмийн ялгаатай байдлуудаас шалтгаалсан гэж үзэж байна.

Дүгнэлт:

1. Хүүхэд сэгсрэх хамшинжийн талаарх ээжүүдийн мэдлэг муу байна. Хүүхэд сэгсрэх хамшинжийн талаарх ээжүүдийн мэдлэг боловсролын түвшингээс хамаарч ялгаатай байна. Мөн давтан төрөгч ээжүүд, анхан төрөгч ээжүүдээс мэдлэгийн хувьд илүү байна.
2. Ээжүүдийн дунд хүүхдээ сэгсрэх дадал их байна. Хүүхдээ сэгсрэх дадал нь тухайн ээжийн ХСХШ-ийн талаарх мэдлэгтэй шууд хамааралтай байна. Сэтгэлзүйн асуудалтай, сүүлийн 1 сарын хугацаанд стресст өртсөн ээжүүд хүүхдээ сэгсрэх дадал давамгайлж байна. Цаашид ээжүүдэд ХСХШ-ийн талаар, хэрхэн урьдчилсан сэргийлэх талаар эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг нэмэгдүүлж хүүхдийн тархины гэмтэлээс урьдчилан сэргийлэх шаардлагатай байна.

Ном зүй:

1. *Ц.Ганцэцэг. Хүүхдийн эрүүл мэндийн үнэлгээ. BGM хэвлэх үйлдвэр2022.*
2. *Foley S, Kovacs Z, Rose J, et al. International collaboration on prevention of shaken baby syndrome - an ongoing project/intervention. Paediatr Int Child Health. 2013;33(4):233-238. 3. Christian CW, Block R, Committee on Child A, Neglect, American Academy of P. Abusive head trauma in infants and children. Pediatrics. 2009;123(5):1409-1411.*
3. *Marcinkowska U, Tyrala K, Paniczek M, Ledwon M, Josko-Ochojska J. Evaluation of knowledge regarding shaken baby syndrome among parents and medical staff. Minerva Pediatr (Torino). 2021;73(1):35-41. 5. AlOmran HI, AlKharaan ZI, AlDawsari KM, AlDakkan OZ, AlAtif HM, Mohamed MZE. Parental awareness, knowledge, and attitude about shaken baby syndrome in Riyadh, Saudi Arabia: a cross-sectional study. Pan Afr Med J. 2022;41:327. 6. Adham SA, Ahmed SM, Ali AS. Mothers' Knowledge, Believes and Attitudes regarding Shaken Baby Syndrome Hazards. Minia Scientific Nursing Journal. 2019;6(1):137-148.*
4. *Alzahrani F, Al-Jabri BA, Ramadan SAL, et al. Parental knowledge and awareness about shaken baby syndrome in Jeddah, Saudi Arabia: a cross-sectional study. Pediatric Reports. 2023;15(2):311-322.*
5. *El Sayed A, Mohamed S. Effect of educational materials on mother's awareness, knowledge and behavior regarding the dangers of shaken baby syndrome. IOSR J Nurs Health Sci. 2020;9:1-7.*

Evaluation of mothers' knowledge and practices about shaken baby syndrom

Batzul J[1], Tumendelger G[1], Urtnasan Ts[1], Narantsetseg E[2]

[1]School of Nursing, MNUMS
E-mail: bn19d054@st.mnums.edu.mn Tel: 976-95373115

Background: Brain damage caused by shaken a baby is called shaken baby syndrome. Because the brains of infants and young children are small and soft, they do not completely fill the skull, so when the child is shaken, the brain hits the skull and causes complications such as stroke, retinal hemorrhage, spinal cord injury, paralysis, seizures, and impaired speech and concentration. . Looking at the results of research conducted in many countries around the world, mothers and caregivers have a low level of knowledge about shaken baby syndrome, so there are many cases of brain damage by shaken their children. was the basis for doing the work.
Aim: To assess the knowledge and practices of mothers about shaken baby syndrome and to determine the factors that influence knowledge and practices.
Materials and methods: The study to evaluate the knowledge and practices of mothers about shaken baby syndrome was carried out using a quantitative research method and a one-moment model. The survey included 19 general knowledge questionnaires, 10 knowledge evaluation questionnaires, 10 knowledge evaluation questionnaires, and 240 mothers with 0-1 year old children who took care of their children between December 25, 2023 and January 30, 2024 3 groups of 39 questionnaires were used to collect data. When assessing mother's knowledge about shaken baby syndrome, 0-59% was defined as poor knowledge, 60-79% as medium knowledge, and 80-100% as good knowledge. The research data was entered into the SPSS25 program and appropriate statistical calculations were made.
Results: 240 (mean age 30.58 ± 6.601) participants were included in the study to evaluate mothers' knowledge about shaken baby syndrome. When assessing mothers' knowledge about shaken baby syndrome, 67.5% had poor knowledge, 17.1% had medium knowledge, and 15.4% had good knowledge. 70% of the participants were repeat mothers and 30% were first-time mothers. 73.6% of first-time mothers had poor knowledge about shaken baby syndrome. There is a statistical difference ($p<0.018$) in the knowledge level of first-time mothers and repeat mothers about shaken baby syndrome. There is a statistical difference ($p<0.023$) in the association of education level with mothers' knowledge about shaken baby syndrome. When evaluating the attitude of the participants in the study, 82.5% of mothers shook their children when their children were restless, when they were stressed, or when they were petting their children. There is a statistically significant difference in relating the practice of shaken your child to psychological problems ($p<0.040$) and being stressed in the last month ($p<0.000$).
Conclusion: Mothers' knowledge about shaken baby syndrome is poor. Mothers' knowledge about shaken baby syndrome varies depending on the level of education. Also, they have more knowledge than repeat mothers and first-time mothers. Mothers with psychological problems and stress in the last 1 month have a habit of shaken their babies.

Keywords: shaken baby syndrome, mothers' knowledge, practices